



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/268


Булган

Эрх олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "В", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, "Булган аймгийн 2019 оны төсөв батлах тухай" аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2018 оны 10/07 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сэлэнгэ сумын төвийн авто замын засварт 20000000 /хорин сая/ төгрөгийг захиран зарцуулах эрхийг Сэлэнгэ сумын Засаг даргад олгосугай.
2. Авто замын засварт зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Сэлэнгэ сумын Засаг дарга /Ш.Насандулам/-д үүрэг болгосугай.
3. Дээрхи хөрөнгийг орон нутгийн авто замын сангаас санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч /О.Сайнзаяа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ